

## ШАР МАНЖИН

### Ач холбогдол:



Үнэр амт сайтай, калци ихээр агуулсан, хүнсэндээ тогтмол хэрэглэвэл ясны сийрэгжилтээс сэргийлдэг. Цусны даралт ихтэй хүн нимгэн зүсэж хөлийн уландаа дэвсэхэд даралтыг бууруулж, тогтмол хэрэглэхэд даралтыг тогтмолжуулдаг.


**Сорт:** Манайд хөдөөгийн улаан, шведийн шар сортуудыг тариалдаг. Үүнээс шведийн шар сорт нь 60-70 хоногт боловсордог.

### Ургах нөхцөл.

Хүйтэнд тэсвэртэй чийгэнд дуртай. Үр нь 6-8°C дулаанд соёолдог. 2-3°C хүйтнийг тэсвэрлэдэг.


**Хөрс боловсруулалт.** Шар манжин тариалах талбайн хөрсийг урд жил нь 1 м талбайд 5-6 кг-аар тооцож бүрэн ялзарсан бууцаар бордож 25-30 см хагалж өвөлжүүлнэ. Хавар цэнэг усалгаа хийсний дараа хөрсийг сайн тэгшилж чулуу хогийг түүж аваад дахин сийрүүлэлт хийсний дараа тарина.

**Тарилт.** Говийн бүсэд хавар IV/20-V/10-ны хооронд үржил шим сайтай хөнгөн шавранцар, урд жил нь бууцаар бордсон талбайд тарина. Эрт тарьж амжаагүй бол VI/25-VII/5 хооронд оройтуулж тарина. Энэ үед тоонолжин цэцэгтний хортонгийн авгалдайн хөнөөл багассан байдаг.



Манжинг эгнээ хооронд 35-40см, ургамал хооронд 3-5см зайтайгаар тарих ба үрийг 1-2 см-ийн гүнд суулгана

### Ээлжлэн тариалалт.



**Усалгаа:** Нэг удаагийн усалгааг хийхдээ 1 ам метр талбайг 40л усаар услана.

Тариалан- гийн бүс	Усалгааны үе шат				
	Говь тал хээрийн бүсэд	1-2 жинэхэнэ навч гарсан үед	5-7 жинэхэнэ навч гарсан үед	Үндэс үр үүсэх үед	Үндэс үр томрох үед

Тариалангий н төв бүсэд	1-2 жинэхэнэ навч гарсан үед		Үндэс үр үүсэх үед		
-------------------------	------------------------------	--	--------------------	--	--

**Тайлбар:** Үндэс үр үүсэх үе гэдэг нь манжингийн үндэс бүдүүрч эхлэх буюу ажиглахад үндэс нь шар өнгөтэй болж амтлахад манжингийн амт нь мэдрэгдэж эхлэх үе юм.

Усалгааг ихдүүлэх багадуулахын аль аль нь хор уршигтай. Учир нь ус ихэдсэн үед ургамлын үндэс агаараар дутагдаж ургалт нь зогсоход хүрдэг. Усалгааг ихэдсэн багадсаныг ажиглаж мэдэж болно. Ихэдсэн үед манжингийн навч давжаарч ургалт нь зогсдог. Багадсан үед мөн ургалт нь зогсох ба харин навч нь хорчийж хугарамтгай болдог

**Арчилгаа.** Талбайд мөр хоорондын сийрүүлэлт хийх, зэрлэг устгах, цөөлөлт хийх арга хэмжээ авна.

	Мөр хоорондын сийрүүлэлтийг усалгаа бүрийн дараа хийнэ. Ингэснээр дөнгөж ургаж байгаа зэрлэг ургамал бүрэн устана. Хөрсний агааржилт сайжирна. Үндэс үр томроно. Чийгийн ашиглалт сайжирна.
	Ургалтын хугацаанд 2 удаа цөөлнө. Цөөлөлтийг усалгааны дараа болгоомжтой хийхгүй бол үлдэж буй ургамал нь гэмтэж үхдэг. Цөөлөлт хийснээр үндэс үр томорч чанартай өндөр ургац авна.

**Цөөлөлт хийх хугацаа ба хоорондын зай:**

Цөөлөлт хийх хугацаа	Үлдэж буй ургамал хоорондын зай
Соёолот жигдэрсэний дараа	5-8 см
Үндэс үр үүсэх үед	10-15см

**Хортонтой тэмцэх:**

Хортонтой тэмцэх арга		Аргачилал
Урьдчилан сэргийлэх ба дайжуулах		1.Эхний ургамал соёолсон өдрөөс эхлэн 3 хоног тутамд аргалын үнс пургиулна. 2.Сармис зэрэг хортон дайжихаар үнэрт бодисууд талбайдаа байрлуулна. 3.Хилэн цэцэг гоньд зэрэг үнэрт тарималуудыг манжингийн талбайд зэрэгцүүлэн тариална.
Устгах	Химийн	Хлорфос, Карбофос, Сумицидин зэрэг хорыг 1л усанд 3 гр-аар найруулж 100 мл талбайд тоосруулан шүршинэ.
	Механик	Түүж устгана
	биологийн	Урагалт жигдэрсэн үед тахиа мэтийн хортонг түүж иддэг амьтадыг талбайд оруулна.

**Хураалт:** 1 м.кв талбайгаас 3кг ургац авна. Манжингийн үндэс үр 8-10 см болсон үеэс эхлэн түүвэрлэн хурааж эхлээд намар 10-20/Х хооронд бүрэн хураан авч ишийг 1-1.5 см урттайгаар тайрч түр зооринд хадгалж байгаад 11-р сараас 90-95%-ийн харьцангуй чийгшилтэй, -1-+1 °С –тай зооринд хадгална.